



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар A/357

Ховд

┌ Сумдын Засаг дарга нарын 2020 оны ┐
ээлжийн амралтанд зохицуулалт хийх тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажлуудын зохион байгуулалт, өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажил болон дэлхий нийтээр тархаад буй “Ковид-19” цар тахлын онцгой нөхцөл байдалтай уялдуулан сумдын Засаг дарга нарын 2020 оны ээлжийн амралтыг 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 8 дугаар сарын 05-ны өдөр ажилд орсон байхаар ажлын 14 хоногоор тооцон олгож, амралтын үлдсэн хоногийг орон нутгийн сонгуулийн дараа олгохоор зохицуулсугай.

2. Ээлжийн амралтын хугацаанд өөрийн чиг үүргийг сумын Засаг даргын орлогчид хариуцуулан, төрийн ажлын тасралтгүй, хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлж ажиллахыг чиглэл болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ